

Ус ашиглах болон хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авахад иргэн, аж ахуй нэгж байгууллагын бүрдүүлэх материалын жагсаалт

Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт заасны дагуу хоногт 50 шоо метрээс бага ус ашиглахад Нийслэлийн байгаль орчны газрын “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг үндэслэн дүүргийн Засаг дарга ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, усны мэдээллийн санд бүртгэнэ.

Ус ашиглах зөвшөөрөл авах аж ахуйн нэгж байгууллага дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

1. “Ус ашиглах зөвшөөрөл” хүссэн тухай дүүргийн Засаг даргад хандсан албан бичиг;
2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. Нийслэлийн байгаль орчны газрын “Ус ашиглуулах дүгнэлт”-ийн хуулбар;
4. Усны нөөц ашигласны төлбөр төлсөн баримтын хуулбар
5. Туул голын сав газрын захиргаанаас “Хаягдал усны дүгнэлт” гаргуулах

Хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу Туул голын сав газрын захиргааны “Хаягдал усны дүгнэлт”-ийг үндэслэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгоно.

Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах ус бохирдуулагч дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

1. “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл” хүссэн тухай дүүргийн Засаг даргад хандсан албан бичиг;
2. Туул голын сав газрын захиргааны “Хаягдал усны дүгнэлт”-ийн хуулбар;
3. Байгууллагын гэрчилгээний хуулбар;
4. Ус бохирдуулсаны төлбөр төлсөн баримтын хуулбар;

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ, ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**

Хаяг: Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Иргэдэд үйлчлэх төв байрны 4 давхар 402 тоот
Утас: 77771965, 94001772

Хариуцсан мэргэжилтэн Б.Эрдэнэзул